

“УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ТЭСВЭРТЭЙ ГЭР ЦЭЦЭРЛЭГ” ТӨСӨЛ

Төслийн зорилго

Гэр цэцэрлэгийг эрчим хүчний хэмнэлттэй, хүрээлэн буй орчинд ээлтэй 5 хүртэлх насны хүүхдийн хөгжлийг дэмжсэн сургалтын таатай орчин болгох зорилготой.

Санхүүжүүлэгч:

Солонгосын хүүхдийн сан

Хэрэгжүүлэгч:

Пипл ин Нийд ОУТББ

Туршилтаар хэрэгжих хугацаа:

2024.10 - 2025.7




Төслийн тойм

Энэхүү туршилтын төсөл нь Улаанбаатар хотын Сүхбаатар, Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн хүүхдийн даац хэтэрсэн цэцэрлэгүүдэд хүлэмжийн хийн ялгарал багатай, эрчим хүчний хэмнэлттэй гэр цэцэрлэгийн 6 бүлгийг байгуулж, 120-150 хүүхдийн эрүүл, таатай орчинд суралцах боломжоор хангах юм. Төслийн хугацаанд эрчим хүчний хэмнэлтийн харьцуулалт, дотор агаарын чанарын хэмжилт болон хүүхдийн хөгжлийн индексийг тодорхойлох мониторинг үйл ажиллагааг зохион байгуулна. Эдгээр туршилт, судалгааны үр дүнд зөвлөмжийг боловсруулж, сайн туршлагыг үргэлжлүүлэх юм.

Үйл ажиллагааны төлөвлөгөө:

Нэг. Гэр цэцэрлэгийг нэмэлтээр дулаалан, агаарын эх үүсвэртэй халаалтын шийдлээр эрчим хүчний хэмнэлтийг бий болгож, дотор агаарын чанарыг хянах.



Энэхүү хүлэмжийн хийн ялгарал багатай шийдэл нь агаарын бохирдлыг бууруулах зорилготой бөгөөд цэцэрлэгт эрчим хүчний хэмнэлтийг бий болгоно.



Агаар сэлгэлтийн системийг гэр цэцэрлэгт суурилуулж, дотор болон гадна агаарын чанарын хэмжсэнээр цэцэрлэгийн орчны агаарын чанарыг дээшлүүлэх.

Хоёр. Хүүхдийн сурч боловсрох орчныг сайжруулахад олон нийтийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх.

- Багш, эцэг эхчүүдэд зориулсан техникийн сургалт болон хүүхдийн хөгжлийн мониторингийг мэргэжлийн зөвлөх явуулах,
- Хүүхдийн өсөлт хөгжилд цэцэрлэгийн орчны цэвэр агаарын ач холбогдлын талаар олон нийтэд мэдээлэл түгээнэ.

Гурав. Эрүүл орчин, цэвэр агаарыг дэмжих хүрээнд дүүргийн удирдлагууд, цэцэрлэгийн албан хаагчид, мэргэжлийн институтыг оролцуулсан бодлогын дэмжлэг үзүүлэх.


- Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй загвар цэцэрлэгийн технологийн тодорхойлолтыг боловсруулна.
- Төслийн эхний шатны туршилтын үр дүнг оролцуулсан зөвлөмж, саналыг бүх оролцогч талуудад өргөн барина.



Сонгинохайрхан дүүргийн гэр цэцэрлэг



Төслийн байршил тус бүрд цэцэрлэгийн багш, ажилчдад халаагуур болон агаарын чанар хянагч төхөөрөмжийн ашиглалт ба агаарын чанарын талаар мэдлэг олгох сургалт тогтмол зохион байгуулж байна.



Гадна агаарын чанар хэмжигч төхөөрөмж нь 24/7 горимоор агаарын чанарын үзүүлэлтийг хэмжих ба мэдээлэл нь олон нийтэд нээлттэй байдаг.



Монгол хүүхдийн хөгжлийг үнэлэх түргэвчилсэн сорил буюу "MORBAS" болон хүүхдийн сэтгэл зүйн эрүүл мэндийг тодорхойлох "SDQ" асуулга ашиглан мэргэжлийн зөвлөх эмч нар нийт 120 хүүхдэд мониторинг хийж, хүүхэд тус бүрийн үнэлгээ болон эцэг эх, сурган хүмүүжүүлэгчдийн зүгээс авах нэн шаардлагатай арга хэмжээг зөвлөн ажиллаж байна.

Холбоо барих:

+976-70111501

info.mongolia@peopleinneed.net

www.mongolia.peopleinneed.net

